



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/574

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, 11.1.5, 11.1.7, 29 дүгээр зүйлийн 29.4, 45 дугаар зүйлийн 45.1.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн 6 дугаар зүйлийн 6.5, 7 дугаар зүйлийн 7.1.4, 7.1.8 дахь заалт, 2024 оны 08 дугаар тогтоолоор баталсан "Говь-Алтай 80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн урамшуулал олгох журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 27 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн аварга шалгаруулах эрүүл мэндийн ажилтнуудын ажил мэргэжлийн 11 төрөлт уралдаан зохион байгуулахад шаардагдах зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2. "Ажил мэргэжлийн уралдаан"-д шаардагдах эмнэлгийн мэргэжилтнүүдийн урамшуулалд 20,790,000 (Хорин сая долоон зуун ерөн мянган) төгрөгийг "Говь-Алтай80+" эрүүл мэндийн хөтөлбөрийн батлагдсан зардлаас гаргаж Эрүүл мэндийн газар О.Баатарчулуун-д шилжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Эрүүл мэндийн газар О.Баатарчулуун-д үүрэг болгосугай

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

